

## Хувилбар D

## Нэгдүгээр хэсэг

1. Монгол орны томоохон талуудын нэг болох Арвайн тал ямар гарал үүсэлтэй вэ? /1 оноо/  
 А. хуримтлалын В. нуурын С. морены D. делювийн E. аллювийн

2. 1921 оны өмнөх засаг захиргааны хуваарийг харуулсан дараах зурагт 5-ын тоогоор ямар аймгийг тэмдэглэсэн байна вэ? /1 оноо/



A. Засагт хан аймаг  
 D. Ховдын хязгаар

B. Сайн ноён хан аймаг  
 E. Сэцэн хан аймаг

C. Түшээт хан аймаг

3. Тэгш хэвтээ байрлалтай чулуулгийн үе давхаргууд тектоник хөдөлгөөний нөлөөгөөр атирааждаг. Атирааны хотгор хэсгийг юу гэдэг вэ? /1 оноо/

A. Горст В. Антиклиналь С. Грабен D. Синклиналь E. Геосинклиналь

4. Дараах химийн нэгдлүүдээс аль нь фотосинтезийн үйл явцын үр дүнд үүсдэг вэ? /1 оноо/

A.  $C_6H_{12}O_6$  B. NaF C.  $SO_2$  D.  $NO_3$  E.  $C_8H_{18}$

5. Цэгийн оронд тохирох үгийг сонгоно уу? /1 оноо/

.....газарзүйн өргөрөг гэнэ.

A. Анхны голдчоос тухайн цэг хүртэлх зэргэдийн нумын өнцгийг


B. Анхны голдчоос баруун зүүн тийш байрлах газарзүйн байрлалыг

C. Анхны голдчоос баруун, зүүн тийш зэргэдийн нумын өнцгөөр тодорхойлогдсон газарзүйн байрлалыг

D. Экватороос хоёр тийших голдчийн нумын өнцгөөр тодорхойлогдсон газарзүйн байрлалыг

E. Дэлхийн төвийг дайруулан татсан шугамыг

6. Дараах бүдүүвчийн асуултын тэмдгийн оронд тохирох үг юу вэ? /1 оноо/



A. Хөдөлмөрийн насны хүн ам

D. Хүн амын цонх үе

B. Бүртгэлтэй ажилгүйчүүд

E. Ажиллах хүч

C. Хүмүүн капитал

7. Нэгдмэл нутаг дэвсгэр, эдийн засаг, сэтгэлзүй, хэл, соёл, бичиг, зан заншлын нийтлэгийн үндсэн дээр түүхэн ёсоор бүрэлдэн тогтсон хүмүүсийг .....гэнэ. /1 оноо/

A. үндэстэн B. угсаатны нийтлэг C. омог D. ястан E. түрэг хэлтэн

8. Байгалийн бэлэн зам ашиглаж их хэмжээний ачаа зөөдөг, өртөг хямд, цаг агаарын нөхцлөөс хамаардаг зэргээр бусад тээврээс ялгаатай тээврийн төрөл юу вэ? /1 оноо/

- A. Авто замын тээвэр      B. Агаарын тээвэр      C. Төмөр замын тээвэр  
D. Усан замын тээвэр      E. Дамжуулах хоолойн тээвэр

9. Монгол орны Газарзүйн шинжлэх ухааны нэрт эрдэмтэн Б.Гунгаадашийн судалгааны чиглэл, голлох бүтээл юу вэ? /1 оноо/

- A. Физик газарзүй, Монгол орны физик газарзүй  
B. Нийгэм эдийн засгийн газарзүй, БНМАУ-ын нийгэм эдийн засгийн газарзүй  
C. Мал аж ахуйн газарзүй, Бэлчээрийн мал аж ахуйн газарзүй  
D. Ус зүй, палеонтологи, Монгол орны агуй, рашаан  
E. Ландшафт судлал, Дорнод Хангайн структур геоморфологийн онцлог

10. Дараах зурагт 2-ын тоогоор юуг тэмдэглэсэн байна вэ? /1 оноо/



- A. Флоридын хойг  
B. Солонгосын хойг  
C. Аляскийн хойг  
D. Камчаткийн хойг  
E. Калифорны хойг

11. Дараах хариултуудад шинэхэн цас, элс, ой мод, хар шорооны альбедео болон дэлхийн нийт альбедог өгчээ. Аль нь дэлхийн нийт альбедео вэ? /1 оноо/

- A. 25      B. 8      C. 30      D. 85      E. 4

12. Дараах зурагт Монгол орны хамгийн том нуур оршдог аймгийг хэдийн тоогоор тэмдэглэсэн байна вэ? /1 оноо/



- A. 2      B. 4      C. 1      D. 3      E. 5


13. Хойд мөсөн далайн хамгийн гүн хонхор аль нь вэ? /1 оноо/

- A. Марианы хонхор /11022 м гүн/
- B. Пуэрто-Рико /8742 м гүн/
- C. Зондын хонхор /7729 м гүн/
- D. Гренландын тэнгис /5527 м гүн/
- E. Сөнөсөн тэнгис /395 м гүн/

14. Дархан-Уул аймгаас зүүн урагш 60 км зайд орших.....орд нь 300-800 мян.тн нүүрсний нөөцтэй. /1 оноо/

- A. Шивээ-Овоо
- B. Тавантолгой
- C. Багануур
- D. Шарын гол
- E. Зүүнбаян

15. Зурагт 3-ын тоогоор тэмдэглэсэн аймаг эдийн засгийн ямар бүсэд багтах вэ? /1 оноо/



- A. Баруун
- B. Зүүн
- C. Хангайн
- D. Төвийн
- E. Улаанбаатарын

16. Монгол орны хойд захын цэгээс өмнөд захын цэг хүртэл хэдэн км байдаг вэ? /1 оноо/

- A. 3485 км
- B. 4676,9 км
- C. 1259 км
- D. 2392 км
- E. 5145 км

17. Дараах корпорациудаас аль нь үндэстэн дамнасан корпораци вэ? /2 оноо/

- A. Mobicom
- B. Tavanbogd
- C. MGL
- D. Mogul
- E. Microsoft

18. Цилиндр тусгагийн уртраг нь шулуун, өргөрөг нь..... хэлбэртэй байдаг. /2 оноо/

- A. шулуун
- B. тойрог
- C. нэг цэгээс цацарсан шулуун
- D. дөрвөлжин
- E. бөөрөнхий


19. 5-р сарын өдрийн дундаж температур  $43^{\circ}\text{C}$ - $48^{\circ}\text{C}$  хүртэл халдаг. Гэвч гэнэт 6-р сарын эхний хагаст далайгаас чийглэг хүйтэн агаар түрэн орж ирж бороо асгарч эхэлнэ. Энэ нь муссоны баяр эхэлсний шинж. Энэ баярыг үзэхийн тулд ямар улсад очих нь зөв бэ? /2 оноо/

- A. Словек
- B. Энэтхэг
- C. Молдав
- D. Австрали
- E. Сири

20. Салхийг хэмжих бол аль багажийг ашиглах вэ? /2 оноо/


- A. Термометр
- B. Барометр
- C. Гигрометр
- D. Флюгер
- E. Луужин

21. Дараах зургийг ажиглаад В үсгийн оронд тохирох хариултыг сонгоно уу? /2 оноо/



- A. Зуны туйл
- B. 147000000 км
- C. Хамгийн богино өдөр
- D. Намрын өдөр шөнийн тэнцэл
- E. 157000000 км

22. Дараах зурагт Монгол орны байгалийн ямар бүсийг үзүүлсэн бэ? /2 оноо/



- A. Хээрийн бүс
- B. Говийн бүс
- C. Цөлийн бүс
- D. Ойт-хээрийн бүс
- E. Уулын босоо бүслүүр

23. Газар хөдлөлтийн дотоод голомтын харалдаа газрын гадарга дээр орших хэсгийг юу гэдэг вэ? /2 оноо/

- A. Гадаад голомт буюу эпицентр
- B. Дотоод голомт буюу төв
- C. Дотоод голомт буюу эпицентр
- D. Гадаад голомт буюу төв
- E. Газар хөдлөлтийн идэвхитэй бүс

24. Хойгт байрлалтай улсууд аль нь вэ? /2 оноо/

- A. Иран, Ирак
- B. Солонгос, Энэтхэг
- C. Афганистан, Узбекистан
- D. Шри-Ланк, Индонез
- E. Монгол, Филиппин

25. Нутаг дэвсгэрийн хэмжээгээрээ 7, 10-р байрт ордог аймгууд аль нь вэ? /2 оноо/

- A. Говь-Алтай, Баянхонгор
- B. Дорноговь, Сүхбаатар
- C. Өвөрхангай, Хэнтий
- D. Завхан, Ховд
- E. Өмнөговь, Дорнод

26. Улаанбаатар хотын нэрний өөрчлөлтийг хугацаатай нь зөв тохируулан бичсэн хариултыг сонгоно уу? /2 оноо/

- A. 1639 оноос Богдын өргөө
- B. 1924 оноос Улаанбаатар
- C. 1913 оноос Нийслэл хүрээ
- D. 1921 оноос Улаанбаатар
- E. 1911 оноос Да хүрээ

27. Монгол улсын одоогийн засаг захиргааны нэгжийг зөв гүйцээх үг юу вэ? /2 оноо/




- A. дүүрэг, хороо
- B. сум, баг
- C. нийслэл, хороо
- D. дүүрэг, сум
- E. нийслэл, сум

28. Монгол улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 5-аас дээш хувийг үйлдвэрлэж байгаа болон үйлдвэрлэх боломжтой ордуудыг стратегийн орд гэнэ. Тэгвэл дараах ордуудаас аль нь стратегийн ач холбогдол бүхий орд вэ? /2 оноо/

- A. Говь-Алтай аймаг - Зээгтийн нүүрсний орд
- B. Дорнод аймаг – Адуунчулууны нүүрсний орд
- C. Дорнод аймаг – Мардайн ураны орд
- D. Хөвсгөл аймаг - Эгийн голын нүүрсний орд
- E. Увс аймаг - Хар тарвагатайн нүүрсний орд

29. Дараах зурагт 1 ба 2-ын тооны оронд бичигдэх төмөр замын өртөөний нэрийг олно уу? /2 оноо/



- A. 1-Чингисийн далан, 2-Эрдэнэт
- B. 1-Мардай, 2- Замын-Үүд
- C. 1-Зүүнбаян, 2-Шарын гол
- D. 1-Салхит, 2- Сайншанд
- E. 1-Тавантолгой, 2- Сүхбаатар


30. Амьтан ургамлын зүйлийн 75% нь өөр хаана ч байдаггүй өвөрмөц онцлогтой, дэлхийн хамгийн өндөр мод болох эвкалипт 600-аад төрөл ургадаг улсын нийслэл нь Канберра хот юм. Энэ ямар улс вэ? /2 оноо/

- A. Парагвай
- B. Боливи
- C. Чили
- D. Румын
- E. Австрали

31. Ховд аймагт 2010 оны байдлаар 36600 ажиллагсад, 1121 бүртгэлтэй ажилгүчүүд байсан бол ажиллах хүч буюу эдийн засгийн идэвхитэй хүн амыг олно уу? /2 оноо/

- A. 1121
- B. 44000
- C. 34100
- D. 37721
- E. 36600

32. Шашны ангилалыг зөв нөхөж гүйцээх хариулт аль нь вэ? /2 оноо/



- A. Католик, Шийт
- B. Протестант, Католик
- C. Күнз, Лал
- D. Үнэн алдартан, Католик
- E. Хинди, Бөө мөргөл

33. Өмнөд Европын улсууд аль нь вэ? /2 оноо/

- A. Австри, Бельги, Швейцар
- B. Швед, Норвеги, Финлянд
- C. Грек, Итали, Португал
- D. Румын, Чех, Унгар
- E. Украин, Гүрж, Югослав

34. Мах, ноос, арьс сүүний чиглэлийн нутгийн шилмэл омгийн тэмээний үүлдэр аль нь вэ? /2 оноо/

- A. Уулын бор, Өнжүүл, Уулын алтай
- B. Баяд, Чамаар, Орхон
- C. Сэлэнгэ, Хар тарлан, Сементаль
- D. Гал шар, Тэс
- E. Галбын говийн улаан, Хэцийн хүрэн, Хос зогдорт

35. 44 сая км<sup>2</sup> талбайтай бөгөөд дэлхийн хамгийн өндөр оргил Эверест, хуурай газрын нам цэг Сөнөсөн тэнгис нь энэ тивд оршдог. Тивийн хойд захын цэг Челюскин хошуу х.ө 78°, өмнөд захын цэг Пиай хошуу х.ө 1°, ойролцоогоор 3,7 тэрбум хүн амтай. Энэ ямар тив бэ? /2 оноо/

- A. Ази
- B. Америк
- C. Африк
- D. Австрали
- E. Европ

36. Монгол улсын нутаг дэвсгэрийн хэмжээ 1564116 км<sup>2</sup> ба 2000 онд 2373500 хүн амтай байсан бол хүн амын нягтшилыг олно уу? /2 оноо/

- A. 1,3
- B. 0,6
- C. 0,9
- D. 1,7
- E. 1,5

37. Зурагт 2-ын тоогоор тэмдэглэсэн гадаргын усны ай савд хамрагдах голууд аль нь вэ? /2 оноо/



- A. Онон, Хэрлэн
- B. Завхан, Тэс
- C. Эг, Орхон
- D. Шишгэд, Хануй
- E. Сэлэнгэ, Идэр

38. Дараах хүснэгтэд өгөгдсөн уур амьсгалын нөхцөл бүхий газар нутаг хаана байж болох вэ? /2 оноо/

	1-р сар	2-р сар	3-р сар	4-р сар	5-р сар	6-р сар	7-р сар	8-р сар	9-р сар	10-р сар	11-р сар	12-р сар
Температур /°C/	29	28	25	20	15	12	11	13	17	21	25	27
Тунадас/ мм/	36	38	28	28	25	28	23	20	20	23	31	36

- A. Австрали
- B. Сибир
- C. Антрактид
- D. Аляск
- E. Баффины газар




39. Дараах зурагт аль тивийн ямар улсын нутаг дэвсгэрийг дүрсэлсэн байна вэ? /2 оноо/



- A. Ази тив-Түрк улс
- B. Европ тив- Франц улс
- C. Ази тив- Индонез улс
- D. Европ тив-Швед улс
- E. Ази тив-Балба улс

40. Дараах зурагт 1 ба 2-ын тоогоор тэмдэглэсэн аймгуудын нэр болон цагийн бүсийн дугаарыг зөв харгалзуулсныг олоорой. /2 оноо/




- A. 1-Говь-Алтай аймаг 6-р бүс, 2-Дорнод аймаг 7-р бүс
- B. 1-Өмнөговь аймаг 7-р бүс, 2-Хэнтий аймаг 8-р бүс
- C. 1-Ховд аймаг 6-р бүс, 2-Хөвсгөл аймаг 8-р бүс
- D. 1-Өвөрхангай аймаг 7-р бүс, Дорноговь аймаг 8-р бүс
- E. 1-Баянхонгор аймаг 7-р бүс, Сүхбаатар аймаг 8-р бүс

41. Өөрийн тодорхой нэр, эзэмшил газар нутагтай, хэл, соёл, сэтгэл зүйн онцлог, зан заншил, уламжлалаар холбогдсон хүмүүсийн нийтлэгийг ястан гэдэг. 2000 оны байдлаар 31,9 мянга гаруй хүн амтай, Монгол улсын нийт хүн амын 1,3 %-ийг эзэлдэг нэгэн ястанг дараах зурагт харуулжээ. Энэ ямар ястан байна вэ? /2 оноо/



- A. Казак
- B. Сартуул
- C. Тува
- D. Дарьганга
- E. Цаатан

42. Дэлхийд ховор, манай улсад нэн ховор болсон Хавтгайн будраа нь байгалийн аль бүсэд ургадаг вэ? /2 оноо/



- A. Хээрийн бүс
- B. Ойн бүс
- C. Тайгын бүслүүр
- D. Ойт хээрийн бүс
- E. Говь-цөлийн бүс

43. Номхон далайн тавцан, Хойд Америкийн тавцангаас зүүн тийш жилд дунджаар 70 мм-ээр холдож байгаа гэж үзвэл 400000 жилийн дараа хоорондын зай нь одоогийнхоос хэдэн км холдох вэ? /2 оноо/

- A. 280000 км
- B. 280 км
- C. 28000 км
- D. 28 км
- E. 2800 км

44. Байгалийн бүс бүслүүр тус бүрт тархах хөрсний хэв шинжийг харгалзуулна уу? /2 оноо/

Байгалийн бүс бүслүүр	Хөрсний хэв шинж
1. Экваторын ой	а. Улаан хүрэн
2. Саванн	б. Чандруулаг
3. Тайга	в. Улаан-шар, ферралит

- A. 1в, 2а, 3б
- B. 1а, 2б, 3в
- C. 1а, 2в, 3б
- D. 1в, 2б, 3а
- E. 1б, 2а, 3в

45. Дараах уул нуруудыг урдаас хойш нь зөв дараалуулсан нь аль нь вэ? /2 оноо/

- A. Байтаг богд, Түргэн, Шүдэн
- B. Лхачинвандад, Хөгнө хан, Цамбагарав
- C. Мөнхсарьдаг, Булнайн нуруу, Ээж хайрхан
- D. Бүтээлийн нуруу, Хөрх, Түргэн
- E. Таванбогд, Тарвагатайн нуруу, Асралт хайрхан


46. Дараах гол мөрдийг цутгах нууртай нь зөв харгалзуулсан хариултыг сонгоно уу? /2 оноо/

- 1. Ховд
- 2. Тэс
- 3. Хэрлэн
- а. Далай нуур
- б. Хар-Ус нуур
- в. Увс

- A. 1а, 2б, 3в
- B. 1б, 2в, 3а
- C. 1в, 2б, 3а
- D. 1а, 2в, 3б
- E. 1в, 2а, 3б



47. Дараах зурагт үзүүлснээр Б-ээс А-рүү очсон жуулчин байгалийн ямар бүсээс ямар бүсэд очсон бэ? /2 оноо/



- A. Экваторын чийглэг ойн бүсээс өндөр уулын бүсэд
- B. Цөлийн ба хагас цөлийн бүсээс өргөн навчит мөнх ногоон ойн бүсэд
- C. Халуун орны хээрээс өндөр уулын бүсэд
- D. Хээрийн бүсээс цөлийн бүсэд
- E. Цөлийн бүсээс өндөр уулын бүсэд

48. Газрын гадаргын хэлбэр дүрс нь дотоод, гадаад олон хүчин зүйлүүдийн үйлчлэлээр үүсдэг. Дараах зурагт үзүүлсэн гадаргын хэлбэр ямар хүчин зүйлийн үйлчлэлээр үүссэн бэ? /2 оноо/



- A. Мөсөн гол
- B. Түр зуурын урсгал ус
- C. Гол мөрөн
- D. Галт уул
- E. Салхи

49. Тэнгисүүдийг орших далайтай нь тохируулна уу? /2 оноо/

- |                     |                    |
|---------------------|--------------------|
| 1. Номхон далай     | a. Чукотын тэнгис  |
| 2. Атлантын далай   | b. Япон тэнгис     |
| 3. Энэтхэгийн далай | c. Андаманы тэнгис |
| 4. Хойд мөсөн далай | d. Карибын тэнгис  |

- A. 1a, 2c, 3d, 4b    B. 1c, 2b, 3a, 4d    C. 1b, 2d, 3c, 4a    D. 1d, 2b, 3a, 4c    E. 1a, 2b, 3d, 4c

50. Далай ван гарагийн нарнаас алслагдах зайг о.о.н ээр илэрхийлнэ үү? /2 оноо/

- A. 1,52    B. 0,72    C. 29,94    D. 5,18    E. 1

**Хоёрдугаар хэсэг.  
Тооцоолох даалгавар**

**Санамж:** Хоёрдугаар хэсэг нь тус бүр 4 оноотой 4 даалгавраас бүрдэнэ. Даалгаврын хариуг хариултын хуудасны хоёрдугаар хэсэгт дараах байдлаар бөглөхийг анхаарна уу?  
Жишээлбэл: Эцсийн хариу 5482 гэж гарсан бол a-5, b-4, c-8, d-2 гэж бөглөнө.

2.1. Монгол орны хойд захын цэг болох Монгол шарын даваанаас мэлхийн зам хүртэл шулуун зайгаар хэдэн км байх вэ?

2.2. 1 см-т 1 км нэрлэсэн масштабтай зураг дээр хоёр хотын хоорондын зай 15 см зурагдсан бол 1 см-т 0.5 км нэрлэсэн масштабтай зураг дээр хэдэн см зурагдах вэ?

2.3. Жижиг автобус 6-р сарын 15-ны өдөр 22 зорчигчтой Улаанбаатар хотоос хөдөлсөн ба нийт 1487 км зам туулж Ховд аймагт очив. Зорчигч тээврийн эргэлт хэдэн хүн.км болохыг бодож олно уу?

2.4. Өргөргийн тойргийн урт 37440 км бол тухайн өргөрөг дээр орших газар нутгуудад дэлхийн тэнхлэгээ тойрон эргэх хөдөлгөөний улмаас үүсэх шугаман хурд хэдэн км/цаг байх вэ?